БАТЛАВ.

| | |
|---|---|
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ | УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗАХИРАЛ |
| .................................... Б.НАРАНТУЯА | .................................... С.ЗУЛПХАР |
| 2017 оны 11 сар 08 өдөр | 2017 оны 11 сар 14 өдөр |

№ 126, УА/20

# ЗАХИАЛГАТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

*Нэг. Нийтлэг зүйл*

1.1. Энэхүү гэрээг богино хугацааны сургалтыг захиалгаар явуулах асуудлаар Эрүүл мэндийн хөгжлийн төв, түүнийг төлөөлж (цаашид Захиалагч гэх) Бодлогын судалгаа удирдлагын сургалтын албаны дарга ***Доржсүрэнгийн Баттулга***, нөгөө талаас (цаашид гүйцэтгэгч гэх) Удирдлагын академи Мэргэжил дээшлүүлэх институтийн захирал ***Дашзэвэгийн Мягмарсүрэн*** нар 2017 оны 11 дүгээр сарын ...-ны өдөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Энэхүү гэрээ нь гэрээнд заасан захиалгат ажлыг гүйцэтгэж дуусгах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

1.3. Гэрээг хоёр хувь үйлдсэн ба хувь тус бүр нь адил хүчин төгөлдөр байна.

1.4. Гэрээ гурван хуудастай.

*Хоёр. Захиалгат ажил, түүний нөхцөл*

2.1. Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид Захиалагч гэх) нь энэ гэрээний дагуу ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 11 дүгээр сарын 17-ны өдөр, нийт 25 хүнийг хамарсан ***"Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ"*** сэдэвт богино хугацааны сургалтыг (цаашид Захиалгат сургалт гэх) Удирдлагын академи (цаашид Гүйцэтгэгч гэх)–д захиалав.

2.2.

| *№* | *Сургалтын сэдэв* | *Хүний тоо* | *Сургалтын цаг* | *Нэг суралцагчийн төлбөр* | *Нийт төлбөр* |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт, хяналт шинжилгээ | 25 | 8 | 48,000 | 1,200,000 |

Төлбөрийг хичээл эхлэхээс 3–5 хоногийн өмнө Захилагч, Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн дагуу захиалагч тал 100 хувь төлөх бөгөөд гүйцэтгэгчийн Худалдаа Хөгжлийн банкин дахь Удирдлагын академи УТҮГ (РД:1700979)-ийн **406091259** тоот дансанд бүрэн төлнө.

4.2. Гүйцэтгэгч нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1. Захиалгат сургалтыг захиалгын дагуу, гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тасралтгүй чанартай явуулах;

4.2.2. Суралцагчдад батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу мэдлэг чадвар олгох ажлыг зохион байгуулах, суралцагчдыг бүхий л сурах нөхцөлөөр хангах;

*4.2.3.* Суралцагчдын сурлагын амжилт, суралцах үйл явцтай холбоотой асуудлаар захиалагчид тогтмол хугацаанд мэдээлэл хүргүүлж байх;

*Тав. Бусад зүйл*

5.1. Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа талууд урьдчилан бичгээр мэдэгдэх ба асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг үүргээ биелүүлээгүй тал бүрэн хариуцна.

5.3. Энэ гэрээтэй холбоотой асуудлаар талуудын хооронд үүссэн маргааныг аль болох харилцан ойлголцох зарчмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан ойлголцож чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэгчийг төлөөлж: |
| --- | --- |
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БОДЛОГЫН СУДАЛГАА УДИРДЛАГЫН СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА | УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН ЗАХИРАЛ |
| Д.БАТТУЛГА | Д.МЯГМАРСҮРЭН |
| 2017 оны ... -р сарын ... -ны өдөр | 2017 оны 11 -р сарын 13-ны өдөр |

Хянасан : М.Цэнгүүн/хуулийн зөвлөх/

Д.Ганутуяа/Ахлах нягтлан бодогч